



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр,
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2014.04.03 № 3/25

Зөрчил арилгуулах тухай

Улсын филармонийн 2013 оны санхүүгийн тайланд аудит хийх явцад дараах зөрчил илэрлээ.

- Санхүүгийн тайлан тэнцлийг эксэл файлаар Т дансаар хөтөлдөг. Т дансны бичилт тодорхой бус, гүйлгээний дүнгүүдийг ямар нэгэн тооцооллоос татаагүй ба шууд шивсэн байсан. Шивсэг тоог үнэн эсэхийг нотлох туслах журнал байхгүй байна.
- Үйлчлүүлэгчидтэй гэрээ хийж тоглолт явуулах нь тус байгууллагын үйл ажиллагааны орлогын нэг хэсэг юм. Үйлчлүүлэгчидтэй гэрээг хийх болон үр дүнг тооцож авлага барагдуулах ажлыг маркетингийн ажилтан гүйцэтгэдэг боловч маркетингийн ажилтнаас авсан гэрээт үйлчилгээний тооцооны бүртгэл нь нягтлан бодох бүртгэл дахь орлого болон авлагын данстай тохирохгүй байна. Тус байгууллагын бүртгэлд харилцагчидтай тооцоо хийсэн авлага өглөгийн данс байдаггүй байна.
- Тоглолтын орлогын зарим хэсгийг балансандаа оруулдаггүй ба түүний зарцуулалтыг мөн бүртгэхгүй, тусад нь баримт үдэж хавсаргасан байна.
- Ажилтнуудын гарт олгохоор тооцоолсон цалин болон банкны карт руу хийсэн дүн хоорондоо зөрүүтэй байна.
- Бид өмнөх жилд аудит хийж эдгээр асуудлуудыг дэвшүүлсэн ба удирдлагад хариуцлага тооцохоор санал оруулж дүгнэлтийг хязгаарлаж, зөвлөмж өгсөн. Гэвч бидний өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д Нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтыг аж ахуйн нэгж байгууллагын удирдлага хэрэгжүүлнэ гэж заажээ. Мөн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д аж ахуйн нэгж, байгууллагын санхүүгийн тайлан нь нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцсэн байх;... 4.1.2-д санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...” Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2009 оны 47 дугаар тушаалаар баталсан “Төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журмын”-ын 3.1.1-д “...алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө” гэсэн заалтуудыг үндэслэн **ШААРДАХ НЬ:**

Дээрх зөрчлийг арилгаж Улсын филармонийн 2013 оны санхүүгийн тайланг залруулах, цаашид ийм алдааг гаргахгүй байхын тулд ажлаа зохион байгуулж ажиллах, биелэлтийг 2013 оны 7 дугаар 25-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Улсын филармонийн дарга Ч.Даваасүрэнд хариуцуулав.

АУДИТОР

Ш.ОТГОНБАЯР

УХА0122